<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>23,337,451.25</b>
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>23,337,451.25</b>
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	23,337,451.25
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>110,753,750.25</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>110,753,750.25</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	35,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,501,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	73,252,150.25
<b>III</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>(976,000.00)</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	976,000.00

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

---

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын үйл ажиллагааны гол зорилгоо “Монгол улсын үндсэн хууль, бусад хууль аймаг сумын удирдлагын бодлогыг чандлан баримталж, үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан төр иргэний харилцааг ил тод нээлттэй болгож, иргэд олон нийтийн санал санаачилгад тулгуурлан төрийн бодлогыг шударгаар хэрэгжүүлэн үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэхэд эрхэм зорилго нь чиглэжээ.

Төрийн албаны нэгдмэл байдлыг хангаж төрийн бодлого шийдвэрийг иргэдэд шуурхай үзүүлж, төрийн бодлого шийдвэрийг цаг алдалгүй хэрэгжүүлнэ” гэж чиг үүргийг тодорхойлжээ.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд тодорхой өөрчлөлт оржээ. Тухайлбал Төрийн хэмнэлтийн тухай хууль батлагдаж, мөрдөгдөж эхэлсэн, тусгай шилжүүлгийн чиг үүргийн байгууллагууд харьяалах дээд шатны байгууллагад нэгтгэдэг болсонтой холбоотой тохируулах бичилтүүд хийгдсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ. Санхүү, төрийн сангийн хэлтэс болон санхүү хяналт аудитын алба санхүүгийн үйл ажиллагаанд хяналт хийдэг байна.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь нийтлэг мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдлөг болгон холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн бүртгэл хөтөлдөг бөгөөд өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримттай болох шаардлагатай байна.

#### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,441.1 сая төгрөгөөр буюу 56 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Банкинд байгаа бэлэн мөнгө	668.9	248.4	(420.5)
Авлага	384.1	238.2	(145.9)
Бараа материал	286.7	96.5	(190.2)
Үндсэн хөрөнгө	4,797.2	2,112.7	(2,684.5)
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>6,137.0</b>	<b>2,695.9</b>	<b>(3,441.1)</b>
Нийт өр төлбөр	32.8	93.9	61.0
Засгийн газрын хувь оролцоо	6,104.1	2,602.0	(3,502.1)
<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>6,137.0</b>	<b>2,695.9</b>	<b>(3,441.1)</b>

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын /Төсвийн төвлөрүүлэн захирагч/  
2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс харахад банкны харилцах дансанд 248.4 сая төгрөг үлдсэнээр мөнгөн хөрөнгө 420.5 сая төгрөгөөр буурсан. Авлага 145.9 сая төгрөгөөр, бараа материал 190.2 сая төгрөгөөр, үндсэн хөрөнгө 2,684.5 сая төгрөгөөр тус тус өссөн байна. Нийт өр төлбөр 61.0 сая төгрөгөөр өссөн байх ба өмчийн хэсэг 3,502.1 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 248.4 сая төгрөг. Өмнөх оноос 420.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Банкинд байгаа бэлэн мөнгө	668.9	248.4	(420.5)
Төгрөг	668.9	248.4	(420.5)
Төрийн сангийн харилцах	663.4	248.4	(415.0)
Арилжааны банк дахь харилцах	4.5	0.0	(4.5)
Нэмэлт санхүүжилтийн харилцах	1.0	-	(1.0)

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын /Төсвийн төвлөрүүлэн захирагч/  
2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төрийн сангийн харилцах дансанд 248.4 сая төгрөг, арилжааны банкинд 0.02 сая төгрөгийн үлдэгдэл үлдсэн байна. Төрийн сангийн харилцах дансны үлдэгдэл 143.4 сая, орон нутгийн хөгжлийн сангийн харилцах дансны үлдэгдэл 72.5 сая, хоршоо хөгжүүлэх сангийн харилцах дансны үлдэгдэл 32.5 сая, Эмийн эргэлтийн сангийн харилцах дансны үлдэгдэл 0.02 сая төгрөг байна. Төрийн сангийн харилцах дансны үлдэгдэл өмнөх оноос 451.6 сая төгрөгөөр буурсан нь дээрх мөнгөн хөрөнгийн бууралт дийлэнх нөлөөлөл үзүүлсэн байна.

### Аудитын илрүүлэлт

- Сумын орлогч даргад нууцын нэмэгдэл болон илүү цаг буруу олгож 1.9 сая төгрөг илүү зарцуулсан. /Баяндэлгэр сумын ЗДТГ/
- Иргэдийн төлөөлөгчдийн хуралд зөвлөхийн орон тоонд ажилтан ажиллуулж 2.4 сая төгрөг илүү зарцуулсан. /ИТХ/

- Төсвийн орлогыг Төсвийн тухай хуулийн дагуу зарцуулаагүй 18.0 сая төгрөгийн зөрчил дутагдал илэрсэн.
- бэлтгэн нийлүүлэгчид төлбөл зохих 2021 оны зардлыг өр төлбөрөөр тусгалгүй тайланд хугацаанд зардал болгосон 3.5 сая төгрөгийн зөрчил дутагдал илэрсэн. /Эмнэлэг/

### 3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 238.2 сая төгрөг болж, өмнөх оноос 145.9 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл* */сая төгрөгөөр/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
<b>Авлага</b>	<b>384.1</b>	<b>238.2</b>	<b>(145.9)</b>
Ажиллагчидтай холбогдсон авлага	3.2	-	(3.2)
Төлбөртэй үйлчилгээний авлага	166.7	-	(166.7)
<b>Бусад авлага</b>	<b>214.2</b>	<b>238.2</b>	<b>24.1</b>
Байгууллагаас авах авлага	3.9	1.3	(2.5)
<b>Хувь хүмүүсээс авах авлага</b>	<b>210.3</b>	<b>236.9</b>	<b>26.6</b>

*Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын /Төсвийн төвлөрүүлэн захирагч/ 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Хоршоо хөгжүүлэх сангаас олгосон зээлийн авлага 236.9 сая, Засаг даргын тамгын газрын авлага 1.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Баяндэлгэр сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны төлбөртэй үйлчилгээний 166.7 сая, бусад 3.7 сая төгрөгийн авлагын үлдэгдэл барагдсан нь авлага буурахад нөлөөлжээ. Хоршоо хөгжүүлэх сангаас олгосон зээлтэй холбоотойгоор бусад авлага 26.6 сая төгрөгөөр өссөн байна. Авлагын 92.4 сая төгрөг тооцоо нийлсэн бол 145.8 сая төгрөг баталгаажаагүй байна.

#### Аудитын илрүүлэлт

Авлагын үлдэгдлийн 223.7 сая төгрөг буюу 93.9 хувь нь 5-аас дээш жилийн насжилттай байх бөгөөд 145.8 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлээгүй байна.

### 3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 96.5 сая төгрөг болж, өмнөх оноос 190.2 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

*Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл* */сая төгрөгөөр/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>286.7</b>	<b>96.5</b>	<b>(190.2)</b>
<b>Түүхий эд материал</b>	<b>33.8</b>	<b>20.1</b>	<b>(13.7)</b>
Эм боох материал	33.8	20.1	(13.7)
<b>Хангамжийн материал</b>	<b>249.1</b>	<b>53.4</b>	<b>(195.7)</b>
Бичиг хэргийн материал	4.4	0.9	(3.4)
Аж ахуйн материал	204.9	51.6	(153.4)
Түлш, шатах тослох материал	2.6	-	(2.6)
Хүнсний материал	1.3	-	(1.3)
Бусад хангамжийн материал	35.9	0.9	(35.0)
Мал амьтад	3.8	23.1	19.2

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын /Төсвийн төвлөрүүлэн захирагч/ 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт бараа материал өмнөх оноос 66 хувиар буурсан ба 21 хувийг түүхий эд хангамжийн материал, 53 хувийг ахуйн материал, 1 хувийг бичиг хэргийн материал, 1 хувийг бусад хангамжийн материал, 24 хувийг мал амьтад эзэлж байна. Сумын ИТХ хурал 0.4 сая, Засаг даргын тамгын газар 76.0, эмийн эргэлтийн сан 20.1 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэл гол нөлөөлөл үзүүлж байна.

### 3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 2,112.7 сая төгрөг болж, өмнөх оноос 2,684.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>4,797.2</b>	<b>2,112.7</b>	<b>(2,684.5)</b>
<b>Биет хөрөнгө</b>	<b>4,704.2</b>	<b>2,060.6</b>	<b>(2,643.6)</b>
Барилга, байгууламж, орон сууц	3,758.1	546.4	(3,211.7)
Хуримтлагдсан элэгдэл	(512.9)	(65.6)	447.2
Авто-тээврийн хэрэгсэл	439.7	396.9	(42.8)
Хуримтлагдсан элэгдэл	(182.9)	(180.3)	2.6
Машин тоног төхөөрөмж(компьютер)	859.1	122.0	(737.2)
Хуримтлагдсан элэгдэл	(482.6)	(49.9)	432.6
Тавилга, аж ахуйн эд хогшил	371.1	53.6	(317.5)
Хуримтлагдсан элэгдэл	(262.9)	(24.5)	238.4
Бусад үндсэн хөрөнгө	1,256.4	1,860.9	604.5
Хуримтлагдсан элэгдэл	(595.0)	(598.8)	(3.8)
Ном	56.0	-	(56.0)
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>93.0</b>	<b>52.1</b>	<b>(40.9)</b>
Програм хангамж	3.9	4.4	0.6
Хуримтлагдсан элэгдэл	(3.3)	(1.0)	2.4
Бусад биет бус хөрөнгө	92.7	49.0	(43.7)
Хуримтлагдсан элэгдэл	(0.3)	(0.4)	(0.1)

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын /Төсвийн төвлөрүүлэн захирагч/ 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант хугацаанд 129.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, үнэ төлбөргүй 10.0 сая төгрөг нэмэгдэж, 32.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө акталсан.

Тусгай шилжүүлгийн байгууллага дээд шатны төсвийн захирагчид шилүүлсэнтэй холбоотой 3,910.9 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн данснаас хассан байна.

Тайлант оны элэгдлийн зардал 147.8 сая, бүтцийн өөрчлөлтөөр данснаас шилжүүлсэн хөрөнгө болон акталсан хөрөнгөтэй холбоотойгоор 1,267.1 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдлийн дансны үлдэгдэл буурсан байна.

Дээрх нөлөөгөөр 2,112.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэлтэй байна.

Иргэдийн төлөөлөгчдийн хурал 0.5 хувь буюу 11.5 сая төгрөг, Эмийн эргэлтийн сан 0.1 хувь буюу 2.5 сая төгрөг, Засаг даргын тамгын газар 99.3 хувь буюу 2,098.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй байна.

### 3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 93.9 сая төгрөг болж, өмнөх оноос 61.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
НИЙТ ӨР ТӨЛБӨР	32.8	93.9	61.0
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	32.8	93.9	61.0
Өглөг	32.8	93.9	61.0
Ажилчидтай холбогдсон өглөг	9.0	-	(9.0)
Бусад өглөг	23.9	93.9	70.0
Байгууллагад төлөх өглөг	19.6	91.1	71.5
Хувь хүмүүст төлөх өглөг	0.0	-	(0.0)
Дансны өглөг /ТӨҮГ/	4.3	2.8	(1.5)

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын /Төсвийн төвлөрүүлэн захирагч/ 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

2022 онд 2,176.6 сая төгрөгийн үйл ажиллагаатай холбоотой өглөг үүссэний 2,115.5 сая төгрөгийн өглөгийг барагдуулсан байна.

Орон нутгийн хөгжлийн сан 64.5 сая төгрөг, Иргэдийн төлөөлөгчдийн хурал 2.5 сая төгрөг, Төрийн сангийн өглөгийн үлдэгдэл 24.1 сая, Эмийн эргэлтийн сангийн өглөгийн үлдэгдэл 2.8 сая төгрөг байна.

#### Аудитын илрүүлэлт:

Нягтлан бодох бүртгэлийн бодлого журмын дагуу үйл ажиллагаагаа зохион байгуулаагүйгээс дансны өглөгийн үлдэгдэл байна. /ЗДТГ/

### 3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 2,695.9 сая төгрөг болж, өмнөх оноос 3,441.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,104.1	2,602.0	(3,502.1)
Засгийн газрын хувь оролцоо	6,104.1	2,602.0	(3,502.1)
Засгийн газрын оруулсан капитал	1,388.5	215.9	(1,172.6)
Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	1,388.5	215.9	(1,172.6)
Хуримтлагдсан үр дүн	3,883.1	2,162.6	(1,720.5)
Өмнөх үеийн үр дүн	2,890.6	5,506.7	2,616.1
Тайлант үеийн үр дүн	992.5	(3,344.1)	(4,336.6)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	832.5	223.5	(609.0)
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	6,137.0	2,695.9	(3,441.1)

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын /Төсвийн төвлөрүүлэн захирагч/ 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хуримтлагдсан үр дүн дансны үлдэгдэл 2,162.6 сая төгрөг болж тайлант үеийн хуримтлагдсан үр дүнгийн 1,304.1 сая төгрөгийн өсөлт, бүтцийн өөрчлөлтөөс хамааран данснаас шилжүүлсэн 4,648.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн бууралт, 1,623.6 сая төгрөгийн НББ-ийн алдааны залруулгаар өсөлтийн үр дүнд 1,720.5 сая төгрөгөөр буурсан байна.

Бүтцийн өөрчлөлттэй холбоотой хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү дансны 609.0 сая төгрөгөөр буурсан байх ба бүтцийн өөрчлөлт хийж хөрөнгө шилжүүлсэнтэй холбогдуулан Засгийн газрын оруулсан капитал 1,172.6 сая төгрөгөөр буурч 215.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй болсон байна.

### **3.5.11 Орлогын данс**

Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын 2022 оны хувь хүний орлогын албан татварын орлого 405.0 сая, хөрөнгийн татварын орлого 209.7 сая, улсын тэмдэгтийн хураамжийн орлого 1.4 сая, газрын төлбөрийн орлого 6.4 сая, ан амьтан, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого 188.1 сая төгрөг болж нийт 810.6 сая төгрөг татварын орлогоор бүрдүүлжээ.

Нийт татварын бус орлого 917.7 сая төгрөг байх ба үүнээс Эмийн эргэлтийн сангийн орлого 89.6 сая, торгуулийн орлого 24.6 сая, бусад орлого 5.4 сая, зээлийн хүүгийн орлого 3.9 сая, үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлого 794.2 сая төгрөг байна.

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн санхүүжилтийн орлого 551.8 сая төгрөгийн санхүүжилт, Сүхбаатар аймгаас авсан санхүүгийн дэмжлэг 280.9, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгийн орлого 2.5 сая төгрөг, Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 35.0 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 73.3 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 261.7 сая төгрөг нийт 2,933.5 сая төгрөгийн санхүүжилт, татварын болон татварын бус орлого орсон.

Энэ нь өмнөх оны орлогоос 3,158.2 сая төгрөгөөр буюу 52 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Баяндэлгэр сумын цэцэрлэг, Сургууль, Соёлын төв, Эрүүл мэндийн төв төсөвт байгууллагууд дээд шатны төсвийн захирагчид санхүүгийн тайланг нэгтгэж байгаатай холбоотой бууралт болсон байна.

Сумын ИТХ-ын тогтоолоор татварын орлого 856.4 сая төгрөг байхаар төлөвлөж, гүйцэтгэлээр 810.6 сая төгрөг төвлөрч, 94.7 хувийн биелэлттэй байна.

Татварын орлогыг 69.6 сая төгрөг буюу 20.7 хувиар давуулан биелүүлсэн ба хөрөнгийн албан татвар 84.6 сая төгрөг буюу 28.7 хувиар тасарсан. Бусад татвар, төлбөр, хураамж 30.8 сая төгрөг буюу 13.6 хувиар тасарсан байна.

Татварын бус орлого нь 724.8 сая төгрөгөөр буюу 96 хувиар тасарсан байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг Орон нутгийн төсвийн орлогоос 1,087.7 сая, Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээс 600.5 сая, өмнөх оны үлдэгдлээс 183.4 сая, Сум хөгжүүлэх сан 87.5 сая, өөрийн үйл ажиллагааны орлогоос 60.0 сая, татварын орлогоор 856.4 сая, Нийт 2,875.5 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэн, нийт зарлагыг 2,875.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн

саналыг тайлант оны төсвийг тодотголоор 2,826.1 сая төгрөгөөр баталж 49.4 сая төгрөгөөр бууруулан баталсан байна.

Энэ бууралт нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу орон тоо цалингийн санг хассанаас шалтгаалсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны төсвийн тодотголоор 49.4 сая төгрөгөөр бууруулсан байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 551.8 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас, 2,146.3 сая төгрөгийг улсын төсвөөс, 60.0 сая төгрөгийг үйл ажиллагааны орлогоос, урьд оны үлдэгдлээс 68.0 сая төгрөг нийтдээ 2,826.1 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээр төлөвлөж, батлуулсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 551.8 сая, улсын төсвөөс 1,847.7 сая төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлого 65.3 сая төгрөг, нийтдээ 2,464.5 сая төгрөг төвлөрүүлсэн.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,427.8 сая төгрөг буюу 86 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь үндсэн үйл ажиллагаа урсгал зардлын төсвийг 129.6 сая төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 243.8 сая төгрөгөөр, эргэн төлөгдөх зээлийг 24.9 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 10. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагаа	1,454.2	1,324.6	(129.6)	91%
2	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	6.4	6.4	-	100%
3	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	43.0	43.0	-	100%
4	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8.0	8.0	-	100%
5	Дотоод эх үүсвэрээр хөрөнгө бэлтгэх	1,201.6	957.8	(243.8)	80%
6	Эргэж төлөгдөх зээл	112.9	88.0	(24.9)	78%
	Нийт дүн	2,826.1	2,427.8	398.3	86%

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын /Төсвийн төвлөрүүлэн захирагч/ 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 9.6 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 25.8 сая төгрөг нийт нэмэлт санхүүжилтийн орлого 35.4 сая төгрөг байна. Үүнээс бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 23.0 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 8.7 сая, хангамж, бараа материалын зардалд 2.4 сая, урсгал засварын зардалд

0.5 сая төгрөг зарцуулсан ба орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг 0.8 сая төгрөг байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 7 хөтөлбөрийн 36 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 11. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт /сая төгрөгөөр/

№	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Иргэдийн төлөөлөгчдийн хурал					
1	Үндсэн үйл ажиллагаа	123.9	119.2	(4.7)	96%
2	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5.0	5.0	-	100%
3	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	23.8	23.8	-	100%
Дүн		<b>152.7</b>	<b>148.0</b>	<b>(4.7)</b>	<b>96%</b>
Засаг даргын тамгийн газар					
1	Үндсэн үйл ажиллагаа	919.8	848.3	(71.5)	92%
2	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	6.4	6.4	-	100%
3	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	19.2	19.2	-	100%
4	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3.0	2.96	(0.04)	99%
Дүн		<b>948.4</b>	<b>876.9</b>	<b>(71.5)</b>	<b>92%</b>
Эмнэлэг					
1	Үндсэн үйл ажиллагаа	41.3	36.9	(4.4)	90%
Дүн		<b>41.3</b>	<b>36.9</b>	<b>(4.4)</b>	<b>90%</b>
Ерөнхий боловсролын сургууль					
1	Үндсэн үйл ажиллагаа	203.8	182.8	(21.0)	90%
Дүн		<b>203.8</b>	<b>182.8</b>	<b>(21.0)</b>	<b>90%</b>
Сургуулийн өмнөх боловсрол					
1	Үндсэн үйл ажиллагаа	120.7	102.3	(18.4)	85%
Дүн		<b>120.7</b>	<b>102.3</b>	<b>(18.4)</b>	<b>85%</b>
Соёл урлаг					
1	Үндсэн үйл ажиллагаа	42.7	35.0	7.7	82%
Дүн		<b>42.7</b>	<b>35.0</b>	<b>7.7</b>	<b>82%</b>
Орон нутгийн хөгжлийн сан					
1	Барилга байгууламж	474.3	323.8	(150.5)	68%
2	Их засвар	132.7	60.7	(72.0)	46%
3	Тоног төхөөрөмж	225.0	146.9	(78.1)	65%
4	Бусад хөрөнгө	369.6	426.4	56.8	115%
Дүн		<b>1,201.6</b>	<b>957.8</b>	<b>(243.8)</b>	<b>80%</b>
Сум хөгжүүлэх сан					
1	Үндсэн үйл ажиллагаа	2.0	0.1	(1.9)	5%
2	Сум хөгжүүлэх сангийн зээл	112.9	88.0	24.9	78%
Дүн		<b>114.9</b>	<b>88.1</b>	<b>26.8</b>	<b>77%</b>
Нийт дүн		<b>2,826.1</b>	<b>2,427.8</b>	<b>(398.0)</b>	<b>86%</b>

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын /Төсвийн төвлөрүүлэн захирагч/ 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын Засаг Даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Миндүг аудит ХХК–ны аудитор Б.Бүзмаа гүйцэтгэж, туслах аудитор Ш.Ундрах, чанарын хяналтыг аудитор С.Энхтөр, хяналтыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын Засаг Дарга нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Миндүг аудит ХХК–д 2023 оны 01 дүгээр сарын 25 -ны өдрийн 04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас 1.5 хувиар буюу 16.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 11.6 сая төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөлтийн үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1<sup>1</sup>, 15.2.3<sup>2</sup>-т зардлын хэмнэсэн эсэхийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулж үзэхэд 1.9-32.1 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Дээрх зардлууд өмнөх оноос өссөн учир шалтгааныг авч үзвэл:

- Гэрэл цахилгаан 8.3 сая төгрөгөөр өссөн нь сумын ихэнх албан газрууд 2021 онд цар тахлын улмаас цахимаар ажил үүргээ явуулж байсан ба аж ахуйн нэгж, байгууллагуудын цахилгааны төлбөрийг төрөөс хариуцсантай холбоотойгоор гэрэл цахилгааны зардал 2022

<sup>1</sup> байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх;

<sup>2</sup> сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилго болон холбогдох бусад зардлыг хэмнэх;

оноос бага гарсан байна.Тайлант онд халаалт, цэвэр бохир усны зардал 32.1 сая төгрөгөөр өссөн.

#### 4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд тайлант хугацаанд оруулбал зохих 54 мэдээллээс, хугацаандаа оруулсан 37 мэдээлэл хугацаандаа мэдээлэгдсэн байна. Хугацаа хоцорсон 15 мэдээлэл байгаа бол огт мэдээлээгүй 2 мэдээлэл байна.

*Шийдвэрлэсэн нь:* Шилэн дансны [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээлэх үүрэгтэй албан тушаалтан мэдээллийг тогтоосон хугацаанд нь тогтмол мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг бүрэн биелүүлж ажиллах энэхүү алдааг гаргахгүй байх зөвлөмж хүргүүлсэн.

##### 4.6.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын Засаг Даргын нь бусад хууль тогтоомжийн хүрээнд асуудалгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.7.1 Завсрын аудитын талаар

Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын тамгын газар нь 2022 онд завсрын аудит хийгээгүй.

##### 4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн биелэлт сайн.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
<b>Зөвлөмж</b>	2	-	2	-	100
Нийт дүн	2	-	2	-	100

#### 4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Баяндэлгэр сумын Засаг даргын үйл ажиллагааны гол асуудал болох хөрөнгийн татвар хураалт ялангуяа малын тоо толгойд ногдуулах албан татварыг бүрэн гүйцэд ногдуулж төсөвт төвлөрүүлэх. Хоршоо хөгжүүлэх сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийг хугацаанд бүрэн гүйцэд төвлөрүүлж, дараа дараагийн жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд боломж олгох асуудалд онцгой анхаарах шаардлагатай.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

---

Баяндэлгэр сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа төсвийн 2 байгууллага, 1 ОНӨҮГ, 2 тусгай сан нийт 5 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс аудитаар нийт 49.1 сая төгрөгийн алдаа<sup>3</sup> илэрснээс аудитын явцад 1.2 сая төгрөгийн алдааг залруулж, 4.5 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 40.1 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 3.4 сая төгрөгийн зөрчилд алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

Цалингийн зардлаас 1.2 сая төгрөгийн гүйлгээг ХХОАТ-ын тайланд илүү татварын өглөг үүсгэсэн байсан алдааг залруулсан байна.

Баяндэлгэр сумын Засаг Даргын 2022 оны нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 107.5 сая төгрөгийн алдаа, зөрчил<sup>4</sup> илэрснээс, 24.9 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 82.6 сая төгрөгийн зөвлөмж өгсөн.

#### 5.1 Албан шаардлага

Хоршоо хөгжүүлэх сангаас олгосон зээл, зээлийн хүүгийн төлбөр гэрээнд заасан хугацаанд төлж барагдуулаагүй, авлага буураагүй байгаа зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

#### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Татварын орлого татан төвлөрүүлэхтэй холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Малын тоо толгойн албан татвар 82.6 сая төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн нь Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 /Албан татвар төлөгчийн өмчилж буй Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа малын тоо толгойд албан татвар ногдуулна/, 5.2 /Тухайн татварын жилд албан татвар ногдуулах малын тоо толгойг Статистикийн тухай хуульд заасны дагуу хийгдсэн өмнөх жилийн мал тооллогын дүнд үндэслэн тодорхойлно./, 6 дугаар зүйлийн 6.2 /Албан татварын хэмжээг энэ хуулийн 6.1-д заасан хязгаарт багтаан сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал малын төрөл тус бүрээр тогтооно/, 7 дугаар зүйлийн 7.1 /Албан татвар төлөгч энэ хуулийн дагуу ногдуулсан албан татварыг тэнцүү хоёр хуваан тухайн жилийн 7 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор өөрийн өмчилж байгаа малын тоо толгой тоологдож бүртгэгдсэн сум, дүүргийн төсөвт төлнө/, Төсвийн тухай хуулийн 41 дугаар зүйлийн 41.2.1 /хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх/, тус тус зөрчсөн байна.

#### **Өгсөн зөвлөмж:**

Малын тоо толгойн албан татварыг төвлөрүүлэх чиглэлээр Багийн засаг дарга, татварын байцаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тодорхой арга хэмжээ болгон тусгаж, биелэлтийг

---

<sup>3</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>4</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хангуулах, мөн уг албан татвараар төвлөрсөн хөрөнгийг буцаан малчдад үйлчилгээ үзүүлэх тохиолдолд татвар төлсөн байдлыг шалгуур үзүүлэлт болгон авч үзэхийг зөвлөж байна

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 09 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

#### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Зээлийн авлага дутуу татан төвлөрүүлсэн	1	24.9			1	24.9						
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>24.9</b>			<b>1</b>	<b>24.9</b>						

#### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
Шилэн дансны цахим системд хугцаа мэдээлэл хоцроосон	1				1			
<b>Дүн</b>	<b>1</b>				<b>1</b>			
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>								
Малын татвар дутуу татан төвлөрүүлсэн	1	82.6					1	82.6
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>82.6</b>					<b>1</b>	<b>82.6</b>
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>82.6</b>					<b>1</b>	<b>82.6</b>